

Итгэлцлийг бэхжүүлэхэд жижиг улсын оруулж буй хувь нэмэр

Тэрбишийн Мөнгөншатар*

Шинжээч, хурандаа, mungunshatar@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Нямцэрэнгийн Цогтгэрэл

докторант, tsogtgerel@mndu.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний батлан хамгаалахын их сургууль

Хураангуй

Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, итгэлцэл, хамтын ажиллагааг түгээн дэлгэрүүлэгч буюу “norm entrepreneur” байдлаар оролцож ирсэн билээ. Энэ хүрээнд Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын бага хурал, “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургууль, “Улаанбаатарын процесс” санаачилгыг “гурван тулгуурт дипломат загвар” байдлаар хөгжүүлж, уламжлал болгон зохион байгуулж байна.

Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын бага хурал нь бүс нутгийн яриа хэлэлцээний индрийг бүрдүүлж чадсан бол “Хааны эрэлд” олон улсын хээрийн сургууль нь энхийг дэмжих ажиллагааны чадавхыг бодитойгоор нэмэгдүүлэхийн зэрэгцээ цэргийн итгэлцэл, харилцан ажиллагааг бэхжүүлж, практик хамтын ажиллагааны суурийг өргөжүүлж байна. Харин Улаанбаатарын процесс нь Зүүн хойд Азийн аюулгүй байдал, бодлогын уялдаа холбоог хэлэлцэх олон талт, нээлттэй платформ болж төлөвшсөн.

Түлхүүр үгс: Монгол Улсын гадаад бодлого, Зүүн хойд Азийн аюулгүй байдал, жижиг улсын дипломат харилцаа, итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ, олон талт аюулгүй байдлын хамтын ажиллагаа

Нэг. Итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ

Итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ (Confidence-Building Measures) нь улс орнуудын хоорондын үл итгэлцэл, тодорхойгүй байдлыг бууруулах, буруу тооцооллоос үүдэх зэвсэгт мөргөлдөөний эрсдэлийг сааруулах, ил тод байдал болон урьдчилан мэдээлэх механизмыг нэмэгдүүлэх замаар харилцан ойлголцол,

*Холбоо барих зохиогч

итгэлцлийг үе шаттайгаар бүрдүүлэхэд чиглэсэн харилцан тохиролцсон арга хэмжээ, журам, механизмын цогц юм (Europe, <https://cdn.osce.org/>, 2011). Олон улсын аюулгүй байдлын судалгаанд итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ нь аюулгүй байдлын дилеммагаас үүдэлтэй үл итгэлцлийг бууруулах, тодорхой бус байдлыг багасгах, зөрчил, хурцадмал байдлыг тогтворжуулахад чиглэсэн практик бодлогын хэрэгсэл гэж үздэг (Glaser, 1997). Итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ нь олон хэлбэртэй байж болох бөгөөд ялангуяа удаан хугацааны зөрчил, сөргөлдөөний нөхцөлд талуудын хооронд бодит итгэлцэл бий болгоход цэргийн болон дипломат чиглэл нь харьцангуй илүү үр нөлөөтэйд тооцогддог (OSCE, 2011). Богино хугацаанд хэрэгжих дээрх арга хэмжээ нь талуудын санаа, зорилгын талаарх буруу ойлголтыг багасгах, цэргийн үйл ажиллагаа, бодлогоос үүдэлтэй үл ойлголцлоос шалтгаалан санамсаргүйгээр зэвсэгт мөргөлдөөнд хүрэх эрсдэлийг бууруулахад чиглэдэг. Энэ утгаараа итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ нь мэдээллийн тодорхой бус байдал, буруу тооцооллоос үүдэх хурцадмал байдлыг хязгаарлах, нөхцөл байдлыг тогтворжуулахад чиглэсэн бодлогын чухал хэрэгсэл болдог.

Урт хугацааны хувьд итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ нь улс хоорондын улс төр, дипломат харилцааны илүү тогтвортой суурийг бүрдүүлэх, аюулгүй байдлын талаарх талуудын ойлголт, хандлагыг аажмаар өөрчлөх, улмаар хамтын аюулгүй байдлын нийтлэг ашиг сонирхлыг тодорхойлох үйл явцыг дэмжих боломжийг бүрдүүлдэг (Jervis, 1978).

Олон улсын харилцаанд итгэлцэл суларч, аюулгүй байдлын орчин хурдацтайгаар өөрчлөгдөж буй өнөө үед жижиг улсууд цэрэг, эдийн засгийн чадавхаар том гүрнүүдтэй өрсөлдөх боломж хязгаарлагдмал байдаг хэдий ч төвийг сахисан байр суурь, уян хатан дипломат бодлого, олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох замаар итгэлцлийг бэхжүүлэх бодит орон зайг бүрдүүлэх боломжтой.

Жижиг улсууд олон улсын харилцаанд “норм бүтээгч” байдлаар оролцож, хамтын ажиллагаа, итгэлцлийг дэмжсэн санаачилгыг дэвшүүлэх замаар өөрсдийн дипломат нөлөөг өргөжүүлэх боломжтойг олон судалгаанд онцолсон байдаг. Тухайлбал: Олон улсын практикт жижиг улсууд итгэлцлийг бэхжүүлэх механизм санаачлах, хэрэгжүүлэх замаар дипломат манлайлал, зуучлал, олон талт хамтын ажиллагааны хэлбэрээр хязгаарлагдмал чадавхаа нөхөж, бүс нутаг болон олон улсын тогтвортой байдалд бодит хувь нэмэр оруулж ирсэн олон жишээ байдаг. Үүний нэг томоохон жишээ бол Финланд хүйтэн дайны үед Зүүн болон Өрнөдийн сөргөлдөөний дунд төвийг сахисан байр сууриа ашиглан дипломат яриа хэлэлцээний индэр бүрдүүлсэн нь 1975 оны Хельсинкийн эцсийн баримт бичгийг батлах нөхцөлийг бүрдүүлсэн. Энэхүү баримт бичиг нь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын суурийг тавьж, цэргийн ил тод байдал, мэдээлэл солилцоо, хүний эрх, хэвлэлийн эрх чөлөө зэрэг өргөн хүрээг хамарсан чухал алхам болсон (OSCE, 2015). Харин Норвег Ойрх Дорнодын

² norm entrepreneur

энхийн хэлэлцээний хүрээнд өрнөсөн Ослогийн үйл явцаар дамжуулан албан бус дипломат сувгаар итгэлцэл бүрдүүлж, улмаар Израил, Палестины албан ёсны хэлэлцээний үндэс суурийг тавьсан нь жижиг улсын “зуучлагч дипломат” бодлогын тод жишээ болж байна (Pruitt, 2007). Эдгээр туршлага нь жижиг улсууд итгэлцлийг бэхжүүлэх санаачилга дэвшүүлэх замаар том гүрнүүдийн хоорондын стратегийн үл итгэлцлийг зөөлрүүлэхээс гадна бүс нутаг болон олон улсын түвшинд тогтвортой байдлыг дэмжих институцийн орчныг бүрдүүлэх боломжтойг харуулж байна. Ийм нөхцөлд жижиг улсууд дипломат идэвх, олон талт хамтын ажиллагааны механизмыг ашиглан олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд бодит хувь нэмэр оруулах боломжтой юм.

Олон улсын аюулгүй байдлын тогтолцоонд институцийн нөлөөлөл харьцангуй суларч, том гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн эрчимжиж буй өнөөгийн нөхцөлд жижиг улсууд дипломат идэвх, олон талт хамтын ажиллагааны механизм, итгэлцлийг бэхжүүлэх санаачилгуудыг ашиглан бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах бололцоо хэвээр байна.

Монгол Улс газарзүйн хувьд Евроазийн эх газарт хоёр том гүрний дунд байрладаг, цэрэг-улс төрийн эвсэлд үл нэгдсэн, “олон тулгуурт, тэнцвэртэй” гадаад бодлого баримталдаг онцлогтой жижиг улс юм. Ийм нөхцөлд Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлын орчинд хүчний тэнцвэрт нөлөөлөхөөс илүүтэй дипломат санаачилга, яриа хэлэлцээний механизм, итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээг дэмжих замаар өөрийн дипломат орон зайг бүрдүүлэхийг зорьж ирсэн. Энэхүү бодлогын хүрээнд Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг дэмжих гурван гол дипломат санаачилгыг хөгжүүлсэн нь Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын бага хурал, “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны хэрийн сургууль, мөн “Улаанбаатарын процесс” юм. Эдгээр санаачилга нь зорилго, механизм, оролцогч талуудын хувьд ялгаатай боловч нийтлэг чиглэлтэй.

Хоёр. Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын бага хурал

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцааг хадгалж, хөгжүүлэхийг гадаад харилцааны бодлогын тэргүүлэх чиглэл хэмээн тодорхойлж, эдгээр улстай үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ гэж заасан байдаг. Энэ нь Монгол Улсын геостратегийн байршил, хоёр том гүрний дунд орших онцлогтой шууд холбоотой бөгөөд үндэсний аюулгүй байдлын тогтвортой байдлыг хангах суурь нөхцөл гэж үздэг. Үүний зэрэгцээ Монгол Улс АНУ, Япон улс, Европын холбоо, БНЭУ, БНСУ, БНТУ зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийг зорьж ирсэн. Энэхүү бодлого нь гадаад харилцааны олон тулгуурт чиг шугамыг институцлах, тэнцвэрийг хадгалах,

эрсдэлийг бууруулах механизмыг бүрдүүлэхэд чиглэж байна. Ийм нөхцөлд Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд идэвхтэй оролцох, яриа хэлэлцээ, итгэлцлийг бэхжүүлэх дипломат санаачилгыг гаргаж, бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмрээ оруулахыг зорьж байна. Энэхүү бодлогын хүрээнд Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх санаачилгыг анх 2009 онд дэвшүүлсэн, анхны хурлаа зохион байгуулсан байдаг.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага шиг институцийн шинжтэй аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бүрэн төлөвшөөгүй байгаа нь тус бүс нутагт яриа хэлэлцээний индэртэй байх хэрэгцээг тодорхойлдог.

Гадаад харилцааны яам, Стратеги судалгааны хүрээлэн хамтран Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” (Ulaanbaatar Dialogue on Northeast Asian Security, UBD) олон улсын бага хурлыг 2014 оноос тогтмол зохион байгуулж ирсэн. Уг санаачилга нь Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаар бүс нутгийн орнуудын төрийн байгууллага, судалгааны хүрээлэн, олон улсын байгууллагын төлөөлөгчдийг нэг индэрт цуглуулж, нээлттэй, олон талт яриа хэлэлцээ өрнүүлэх зорилготой 1.5 форматын дипломат механизм юм (Institute for Strategic Studies of Mongolia, 2023).

Зүүн хойд Азийн бүс нутаг нь өнөөдөр дэлхийн стратегийн өрсөлдөөний чухал төвүүдийн нэг болж, Умард Солонгосын цөмийн асуудал, том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн, эдийн засгийн харилцан хамаарал зэрэг олон сорилттой тулгарч байна. Тус хурлаар Зүүн хойд Азийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, боломж, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, итгэлцлийг бэхжүүлэх үндсэн асуудлыг хэлэлцэхийн зэрэгцээ бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлттэй уялдан олон улсын бага хурлын хамрах хүрээ, хэлэлцэх асуудал, оролцогчдын тоо жилээс жилд өргөжиж байна.

Суурь аюулгүй байдал ба итгэлцэл (2014-2016): Олон улсын бага хурал эхний жилүүдэд уламжлалт аюулгүй байдал, стратегийн үл итгэлцэл, Зүүн хойд Азид институцийн шинжтэй аюулгүй байдлын механизм үгүйлэгдэж буй асуудалд төвлөрч байв. Тухайн үед бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий үнэлгээ хийх, итгэлцлийг бэхжүүлэх боломжит арга замыг хэлэлцэх, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхэд чиглэж байсан. Үүний үр дүнд “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” хурал төвийг сахисан, нээлттэй орчныг бүрдүүлсэн дипломат индэр болж төлөвшсөн.

Шинэ сорилт ба аюулгүй байдлын ойлголтын өргөжилт (2017-2019): Олон улсын бага хурал 2017 оноос уламжлалт аюулгүй байдлын асуудлаас хүрээгээ тэлж, эрчим хүчний аюулгүй байдал, дэд бүтцийн холболт, байгаль орчны аюулгүй байдал зэрэг өргөн хүрээний асуудлыг хамрах болсон. Энэ нь бүс нутгийн тогтвортой байдал зөвхөн цэрэг-улс төрийн хүчин зүйлээр хязгаарлагдахгүй, харин эдийн засгийн харилцан хамаарал, дэд бүтцийн уялдаа холбоо, эрчим

хүчний нийлүүлэлтийн найдвартай байдал зэрэг олон хүчин зүйлтэй холбогдож буйг харуулж байна.

Цар тахлын дараах нөхцөл ба олон талт хамтын ажиллагаа (2022-2023): “COVID-19” цар тахлын дараах нөхцөлд эдийн засгийн сэргэлт, ханган нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдал, хүмүүнлэгийн хамтын ажиллагааны талаарх асуудал хурлын үндсэн сэдэв болсон. Үүний зэрэгцээ том гүрнүүдийн өрсөлдөөн, Украины дайн зэрэг геополитикийн хурцадмал байдал нь бүс нутгийн хамтын ажиллагааны ач холбогдлыг нэмэгдүүлж, “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” хурлын хамрах хүрээг өргөжүүлсэн.

Уур амьсгал, эрчим хүчний шилжилт ба бүс нутгийн холболт (2024-2025): Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний шилжилт, цахилгаан эрчим хүчний сүлжээний холболт, чухал ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээ зэрэг асуудалд чиглэсэн нь аюулгүй байдлын асуудлыг урт хугацааны тогтвортой хөгжлийн асуудалтай уялдуулан авч үзэх хандлага бэхжиж байгааг илэрхийлнэ. Мөн Зүүн хойд Ази болон Төв Азийн хамтын ажиллагааг 2025 онд анх удаа тусгайлан хэлэлцсэн нь “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” газарзүй, стратегийн хүрээгээ өргөжүүлж, бүс нутгуудыг холбосон дипломат платформ болон хөгжиж байгааг харуулж байна.

Гурав. Олон улсын энхийг дэмжих ажиллагааны “Хааны эрэлд” хээрийн сургууль

Монгол Улсын Зэвсэгт хүчнийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын эвслийн ажиллагаанд оролцуулах төрийн бодлого нь батлан хамгаалах салбарын шинэчлэлийн чухал чиглэлүүдийн нэг бөгөөд бие бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэл, сургалтыг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэхэд чиглэж ирсэн. Энэхүү бодлогын хүрээнд Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадавхыг бэхжүүлэх зорилгоор олон улсын хамтарсан сургуулилтыг тогтмол зохион байгуулж ирсний хамгийн тод жишээ нь “Хааны эрэлд” (Khaan Quest) олон улсын энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургууль юм. “Хааны эрэлд” сургуулийг анх 2003 онд Монгол Улсын Зэвсэгт хүчин болон АНУ-ын Номхон далайн цэргийн командлал (PACOM)-ын дэмжлэгтэйгээр Монгол, Америкийн тэнгисийн явган цэргийн хоёр талт хамтарсан хээрийн сургуулиар эхлүүлсэн. Улмаар энэхүү сургууль нь шат дараатай өргөжин, бүс нутгийн болон олон улсын энхийг сахиулах сургуулилтын түвшинд хүрч хөгжсөн.

АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлал (USINDOPACOM) болон Дэлхийн энхийн санаачилга (Global Peace Operations Initiative)-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төв (Таван толгой)-д сүүлийн жилүүдэд уламжлал болгон зохион байгуулж байна (United States Indo-Pacific Command, 2023). Хээрийн сургуулийн цар хүрээ өргөжин, олон улсын оролцоо нэмэгдэхийн хэрээр уг сургуулилт нь цэргийн хамтын ажиллагааны талбар

болон хөгжиж, Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг батлан хамгаалах салбарын түвшинд бодитоор хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Улмаар бие бүрэлдэхүүний мэргэжлийн чадавх, сургалтын стандарт, ур чадварыг олон улсын түвшинд хүргэхийн зэрэгцээ батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг дэмжсэн бодит механизм болон төлөвшсөн байна. “Хааны эрэлд” энхийг сахиулах хээрийн сургуульд одоогийн байдлаар давхардсан тоогоор 70 орчим улсын 19662 цэргийн алба хаагч оролцсоноос 12290 нь Монгол, 7372 нь гадаадын оролцогчид байна (Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, 2023).

Оролцогч орнуудын өргөн хүрээтэй, тогтвортой оролцоо нь “Хааны эрэлд” сургуулийг сургалтын шинж чанараас давсан, энхийг сахиулах ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, харилцан ажиллагааг гүнзгийрүүлэх, итгэлцлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн институцчилсэн олон улсын платформ болж төлөвшсөнийг илтгэнэ. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний оролцоо нэмэгдэхийн хэрээр олон улсын ажиллагааны стандарт, дүрэм, ажиллагааны аюулгүй байдал зэрэг зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх сургалтын хэрэгцээ, шаардлага нэмэгдсэн. Энэхүү хэрэгцээг хангах сургалтын цогц орчныг бүрдүүлж, бодит ажиллагаанд суурилсан тус сургалтаар дамжуулан энхийг сахиулах ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэлийг хангах боломжийг бүрдүүлэх болсноороо онцлог байна. Сургуулийн хүрээнд команд-штабын сургууль (Command Post Exercise), салаадын хээрийн сургууль (Field Training Exercise), мөн чадавх нэмэгдүүлэх сургалтыг (Critical Capacity Enabler Enhancement) зохион байгуулснаар НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох бүрэлдэхүүний төлөвлөлт, шийдвэр гаргах чадвар, тактикийн бэлтгэл, олон улсын хамтарсан ажиллагаанд оролцох харилцан ажиллагааны чадавхыг дээшлүүлэхэд чиглэж байгаа (United Nations, 2020).

Команд-штабын сургууль нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны штабын түвшинд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний үүссэн нөхцөл байдлыг үнэлэх, шийдвэр гаргах, ажиллагааны төлөвлөлтийн чадавхыг хөгжүүлэхэд чиглэдэг. Үүний хүрээнд мэдээллийн удирдлага, нөхцөл байдлын үнэлгээ, мөн олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагуудтай харилцан ажиллагаа явуулах мэдлэг, ур чадварыг төлөвшүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг. Мөн Монгол Улс, АНУ-ын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд чадавх нэмэгдүүлэх сургалтуудыг явуулдаг. Үүнд цэргийн эрх зүй, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн хэрэглээ, тэсрэх бодис устгах чиглэлийн ахисан шатны сургалтууд багтдаг бөгөөд сургуулийн бодит үр нөлөө, мэргэжлийн түвшнийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

“Хааны эрэлд” олон улсын энхийг сахиулах хээрийн сургуулийн ач холбогдлыг улс төрийн, цэргийн болон олон улсын харилцааны түвшинд авч үзэх нь Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийг илүү бодитой тодорхойлох боломж олгодог. Тухайлбал:

Улс төрийн түвшин: Батлан хамгаалах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, гадаад бодлогын үзэл баримтлалтай уялдуулах бодит механизм болж байна. Тус сургууль нь “гуравдагч хөрш”-ийн бодлогыг бодит хамтын ажиллагаанд шилжүүлж, батлан хамгаалах салбарын олон улсын нэр хүндийг өсгөж, зөөлөн хүчний нөлөөг тэлэхэд дэмжлэг болдог. Үүний зэрэгцээ батлан хамгаалах бодлогын талаарх олон нийтийн ойлголт, дэмжлэгийг өргөжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Батлан хамгаалах чадавх ба бэлэн байдал: Манай улсын энхийг сахиулах чадавхыг нэмэгдүүлэхэд бодитой нөлөө үзүүлж ирсэн. Сургууль нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний бэлтгэлийг хангах, цаашлаад нөөцийг тогтвортой бүрдүүлэх боломжийг олгодог.

Олон улсын харилцаа, бүс нутагт эзэлж буй байр суурь: Монгол Улсыг бүс нутгийн энхийг дэмжих орчинд идэвхтэй оролцогчоор байршуулж, хараат бүс байдлаа хадгалах, тэнцвэржүүлсэн гадаад бодлого хэрэгжүүлэх боломжийг өргөжүүлж байна. Тус сургууль нь Монгол Улсыг энхийг сахиулах ажиллагаанд оролцогч төдийгүй туршлага, мэдлэг түгээгч улс гэсэн байр сууринд ойртуулж байна. Түүнчлэн оролцогч орнуудтай итгэлцэлд суурилсан цэргийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, бүс нутагт энхийг дэмжих сургалтын зангилаа төв болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Дөрөв. Улаанбаатарын процесс

Зүүн хойд Азийн бүс нутагт хүйтэн дайны дараах геополитикийн хурцадмал байдал, цөмийн зэвсгийн тархалтын эрсдэл, нутаг дэвсгэрийн маргаан, мөн их гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн үргэлжилсэн хэвээр байна. Өөрөөр хэлбэл: Солонгосын хойгийн цөмийн асуудал, Америк-Хятадын стратегийн өрсөлдөөн, Орос-Өрнөдийн харилцааны хурцадмал байдал зэрэг хүчин зүйлс нь бүс нутгийн аюулгүй байдлын орчныг эмзэг, тодорхой бүс хэвээр хадгалж байна. Ийм нөхцөлд “Улаанбаатарын процесс” (Ulaanbaatar Process, UBP) нь Зүүн хойд Азид энх тайван, тогтвортой байдлыг дэмжих зорилготой иргэний нийгэмд тулгуурласан яриа хэлэлцээний механизм болон төлөвшиж байна. Уг санаачилга нь бүс нутгийн орнуудын бодлого боловсруулагчид, судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудыг нэг индэрт цуглуулж, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг олон талт хэлэлцүүлгийн хүрээнд авч үзэх боломжийг бүрдүүлдэг.

“Улаанбаатарын процесс” нь Зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх дэлхийн түншлэл (Global Partnership for the Prevention of Armed Conflict)-ийн хүрээнд хэрэгждэг бөгөөд бүс нутгийн итгэлцлийг бэхжүүлэх, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, бодлогын түвшний хэлэлцүүлэгт иргэний нийгмийн оролцоог өргөжүүлэхэд чиглэдэг (GPPAC, 2022). Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус, цөмийн зэвсэгтэй гүрнүүдээс авсан аюулгүй байдлын баталгаа, мөн бүс нутгийн бүх улстай тогтоосон тэнцвэртэй харилцаа нь Монгол Улсыг итгэл даахуйц, төвийг сахисан яриа хэлэлцээний талбар болгон ашиглах нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь “Улаанбаатарын процесс”-ыг бүс нутгийн дипломат санаачилгууд дунд онцгой

байр суурь эзлэхэд нөлөөлж байна. Тус процесс нь аюулгүй байдлын уламжлалт ойлголтоос давсан, өргөн хүрээний асуудлуудыг хамарч байна. Үүнд: цөмийн зэвсгээс ангид бүс байгуулах санаачилга, итгэлцэл бэхжүүлэх арга хэмжээ, хүний аюулгүй байдал, жендерийн тэгш оролцоо, залуучуудын оролцоо, уур амьсгалын өөрчлөлт ба аюулгүй байдлын уялдаа зэрэг орчин үеийн аюулгүй байдлын асуудал багтдаг. Ингэснээр “Улаанбаатарын процесс” нь бүс нутагт итгэлцэл бий болгох орон зай бүрдүүлэх, албан ёсны дипломат сувгийг дэмжих, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, бодлогын хэлэлцүүлэгт нөлөөлөх зэрэг олон талт үүрэг гүйцэтгэж байна. Албан ёсны дипломат сувгууд хязгаарлагдмал нөхцөлд ийм төрлийн албан бус яриа хэлэлцээний механизм нь стратегийн үл итгэлцлийг бууруулах, бүс нутгийн тогтвортой байдлыг дэмжихэд урт хугацааны эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын бага хурал, “Хааны эрэлд” олон улсын энхийг дэмжих ажиллагааны хээрийн сургууль, “Улаанбаатарын процесс” санаачилга нь бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлэлцээний тогтвортой индэр болохын зэрэгцээ цэрэг-цэргийн итгэлцлийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны соёлыг төлөвшүүлэх замаар стратегийн үл итгэлцлийг бууруулах “гурван тулгуурт дипломат загвар” байдлаар хөгжиж байна. Том гүрнүүдийн стратегийн өрсөлдөөний дунд харьцангуй төвийг сахисан, итгэл даахуйц орон зайг хадгалж чадсан нь жижиг улсын дипломат маневрын боломж бодитой болохыг харуулж байна. Энэ нь жижиг улсууд олон улсын аюулгүй байдлын орчинд хүчний тэнцвэрт нөлөөлөхөөс илүүтэй итгэлцэл, хэм хэмжээ, хамтын ажиллагааг дэмжих замаар “norm entrepreneur” байдлаар оролцох боломжтойг онол, практикийн түвшинд нотолж байгаа юм.

Дүгнэлт

Монгол Улсын санаачлан хэрэгжүүлж буй Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа, хэлэлцээ” олон улсын бага хурал, “Хааны эрэлд” олон улсын хээрийн сургууль, “Улаанбаатарын процесс” зэрэг санаачилга нь зорилго, механизм, оролцогч талуудын хувьд ялгаатай боловч стратегийн хувьд харилцан нөхөх шинжтэй гурван тулгуурт дипломат загварыг бүрдүүлж байна. Тодруулбал: нэгдүгээрт, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлэлцээний тогтвортой индэр; хоёрдугаарт, цэргийн итгэлцэл, харилцан ажиллагааг бэхжүүлэх практик хамтын ажиллагааны талбар; гуравдугаарт, бодлогын болон иргэний нийгмийн түвшний итгэлцлийн сүлжээг бүрдүүлэх механизм гэсэн гурван түвшинд давхар нөлөө үзүүлж байна.

Бодлогын түвшинд дээрх гурван санаачилга нь Монгол Улсын бие даасан байдал, олон тулгуурт гадаад бодлогыг бэхжүүлэх, олон улсын нэр хүндийг нэмэгдүүлэх, бүс нутгийн тогтвортой байдалд бодит хувь нэмэр оруулах стратегийн хэрэгсэл болон төлөвшсөн. Гэвч том гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөн эрс хурцдаж, нөлөөллийн хүрээгээ тэлэх ашиг сонирхлоо ил тод зарлан, бодитоор хэрэгжүүлж эхэлсэн түрэмгий алхмууд нь бусад улс орнуудын

сул, ёс төдий эсэргүүцэлтэй тулгарч, бүс нутгуудын аюулгүй байдлын орчныг ноцтойгоор доройтуулж байна. Ялангуяа харьцангуй тогтвортойд тооцогдож ирсэн Зүүн Хойд Азид Тайваний хоолой, Солонгосын хойг, Өмнөд Хятадын тэнгис зэрэг халуун цэгүүдийн хурцадмал байдал хяналтаас гарч, зэвсэгт мөргөлдөөнд хүрвэл бүс нутгийг хамарсан томоохон дайн дэгдэх эрсдэлтэй. Ийм нөхцөлд олон улсын аюулгүй байдлын орчинд стратегийн үл итгэлцэл гүнзгийрч, их гүрнүүдийн өрсөлдөөн ширүүссэн тохиолдолд итгэлцэлд суурилсан, уян хатан дипломат механизмын стратегийн ач холбогдол урьд урьдаас илүү өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсын гадаад бодлогын дээрх санаачилгуудыг цаашид өргөжүүлэхдээ тэдгээрийн цар хүрээг дангаар нэмэгдүүлэхээс илүүтэйгээр гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын зорилтуудтай уялдуулан төрийн бодлогын түвшинд нэгтгэн хөгжүүлэх шаардлагатай. Үүний тулд уг санаачилгуудыг салбар хоорондын уялдаа бүхий нэгдсэн бодлогын механизмд хамруулж, төрийн байгууллагуудын зохицуулалт, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зүйтэй. Түүнчлэн олон улсын байгууллага, бүс нутгийн түншүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх замаар эдгээр санаачилгын үр нөлөө, тогтвортой байдал, залгамж чанарыг хангах шаардлагатай. Эдгээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлснээр уг санаачилгууд нь дан ганц арга хэмжээний шинжээс давж, бүс нутгийн итгэлцлийг бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах, яриа хэлэлцээг дэмжих замаар Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын орчныг тогтворжуулах Монгол Улсын дипломат арга хэрэгсэл болон төлөвших боломжтой.

Эх сурвалжийн жагсаалт

- Bailes, A. J. K., & Thorhallsson, B. (2013). *Instrumentalizing the European Union in small state strategies*. *Journal of European Integration*, 35(2), 99-115.
- Finnemore, M., & Sikkink, K. (1998). International norm dynamics and political change. *International Organization*, 52(4), 887-917.
- Glaser, C. L. (1997). The security dilemma revisited. *World Politics*, 50(1), 171-201.
- Jervis, R. (1978). Cooperation under the security dilemma. *World Politics*, 30(2), 167-214.
- Organization for Security and Co-operation in Europe. (2011). *Vienna document 2011 on confidence- and security-building measures*.
- Organization for Security and Co-operation in Europe. (2015). *The Helsinki Final Act and the OSCE*.
- Pruitt, D. G. (2007). *Whither ripeness theory?* *International Negotiation*, 12(3), 377-398.
- Institute for Strategic Studies of Mongolia. (n.d.). *Ulaanbaatar Dialogue on Northeast Asian Security initiative*. Retrieved from
- Office of the President of Mongolia. (2023, June 19). *Opening of the "Khaan Quest-2023" multinational peacekeeping exercise*.
- GPPAC. (2022). *Global Partnership for the Prevention of Armed Conflict: Northeast Asia program*.

The Contribution of small states to confidence-building measures

Mungunshatar Terbish

Research Fellow, Colonel, mungunshatar@iss.gov.mn
The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Tsogtgerel Nyamtseren

Ph.D., candidate, tsogtgerel@mndu.gov.mn
Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia

Abstract

Mongolia has pursued a peaceful, open, independent, and multi-pillared foreign policy, actively contributing to international and regional security as a “norm entrepreneur” promoting international legal principles, shared norms, mutual trust, and cooperative engagement. In this context, Mongolia has developed and institutionalized a “three-pillar diplomatic model” comprising the Ulaanbaatar Dialogue on Northeast Asian Security, the Khaan Quest International Peacekeeping Exercise, and the Ulaanbaatar Process initiative.

The Ulaanbaatar Dialogue on Northeast Asian Security has established an inclusive platform for sustained regional dialogue among governments, experts, and other stakeholders. The Khaan Quest International Peacekeeping Exercise has significantly enhanced peacekeeping operational capabilities, strengthened military confidence-building, improved interoperability among participating forces, and expanded the foundation for practical defense cooperation. Meanwhile, the Ulaanbaatar Process has evolved into a multi-stakeholder, open forum for addressing regional security challenges and promoting policy coherence and trust-building in Northeast Asia.

Keywords: *Mongolian foreign policy, Northeast Asian security, small state diplomacy, confidence-building measures, multilateral security cooperation*